

“ХӨВСГӨЛ” ХК

2024 оны 04 сарын 30

№ 24/05

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан
хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас
тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.8, 62.1.15 дахь заалт, 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 24/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компаниас нэмж гаргах 86,655,338 (*наян зургаан сая зургаан зуун тавин таван мянга гурван зуун гучин найм*) ширхэг энгийн хувьцаанаас хувьцаа эзэмшигчдэд өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Тэргүүн ээлжид худалдах энгийн хувьцааны зах зээлийн үнийг нийтэд санал болгож буй зах зээлийн нэгж үнэтэй тэнцүү байхаар тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1-д заасан Компанийн нийт зарласан хувьцаанаас хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д эзэмшүүлэх нөхцөлийг тогтоох, эдгээртэй холбоотой бусад шийдвэрийг тухай бүр гаргах, энэхүү тогтоолыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА